



I-III/2022

Тархаасан: 2022 оны 5 дугаар сарын 12



## Дотоод худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 26.5 хувиар өслөө

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны эхний улиралд 7.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.5 (26.5%) их наяд төгрөгөөр өслөө. Инфляцийн дүнгээр завсарласан бодит өсөлт өмнөх оны мөн үеэс 11.6 хувиар өслөө.

Үүнд шатахууны жижиглэн худалдаа 511.2 (51.8%) тэрбум төгрөг, бөөний худалдаа 293.8 (53.1%) тэрбум төгрөг, хүнсний төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа 129.2 (22.4%) тэрбум төгрөг, эм, гоо сайхан, ариун цэврийн барааны жижиглэн худалдаа 114.6 (47.1%) тэрбум төгрөг, төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа 102.0 (29.7%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны 3 дугаар сард 2.7 их наяд төгрөг болж, өмнөх сараас 687.0 (35.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО<sup>1</sup>, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар


	2020		2021		2022*		2022* I-III 2021 I-III
	III	I-III	III	I-III	III	I-III	
	тэрбум төгрөг						хувь
<b>Нийт</b>	<b>1 530.4</b>	<b>4 579.4</b>	<b>2 107.4</b>	<b>5 536.1</b>	<b>2 650.9</b>	<b>7 002.3</b>	<b>126.5</b>
Бөөний худалдаа	547.7	1 692.8	819.2	2 180.0	1 099.0	2 842.6	130.4
Жижиглэн худалдаа	982.7	2 886.6	1 288.1	3 356.1	1 551.9	4 159.7	123.9

<sup>1</sup> Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн санд үндэслэсэн тооцоо

Худалдааны салбарын 2022 оны эхний улирлын борлуулалтын орлогын 40.6 хувь нь бөөний худалдаа, 59.4 хувь жижиглэн худалдааны салбарт ногдож байна.

Жижиглэн худалдааны борлуулалтын орлого 2022 оны эхний улиралд 4.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 803.6 (23.9%) тэрбум төгрөг, бөөний худалдааны борлуулалтын орлого 2022 оны эхний 3 сард 2.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 662.5 (30.4%) тэрбум төгрөгөөр тус тус өслөө.

ЗУРАГ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, сараар, тэрбум төгрөгөөр




Худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны 3 дугаар сард өмнөх сараас 687.0 тэрбум төгрөгөөр өсөхөд хүнсний бөөний болон жижиглэн худалдаа 41.7-76.3 тэрбум төгрөгөөр, шатахууны бөөний болон жижиглэн худалдаа 45.9-85.1 тэрбум төгрөгөөр, моторт тээврийн хэрэгслийн сэлбэг, эд ангийн

жижиглэн худалдаа 85.0 тэрбум төгрөгөөр, төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа 73.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны эхний улиралд Төв аймагт өмнөх оны мөн үеэс 2.0 дахин өссөн бол бусад аймгуудад 2.6-62.7 хувиар өссөн байна. Харин Өмнөговь аймагт 2022 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 11.2 хувиар буурсан байна.

ЗУРАГ 2. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, аймгаар, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар, тэрбум төгрөгөөр



**Ойлголт, тодорхойлолт**

**Худалдааны нийт үйлдвэрлэлд** бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудын худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, ажиллагчдадаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс олсон орлого, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй)-г оруулна.

**Худалдааны салбарын нийт борлуулалт** нь тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалт бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын цэвэр борлуулалтын нийлбэрээр тооцно.



**Эх үүсвэр:**

ҮСХ, Дотоод худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын сарын мэдээ;  
НӨАТ төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн сан;

**Ангилал, код:**

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 4.0

**Мэдээлэл авах холбоос:**

<http://www.nso.mn/>  
<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ гархаах хуваарь:**

2022 оны 6 дугаар сарын 13

Эдийн засгийн статистикийн  
газрын дарга А.Дэмбэрэл  
Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн  
газрын статистикч Л.Энхбаатар  
Утас: (976-51)-264797

